

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ
2025 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Сургалт, хэмжээ	арга	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах нэгж	Биелэлт
Нэг. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, салбарын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт								
1.1.	Салбарын төрийн захиргааны болон төв, орон нутгийн харьяа байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах		Сургалтад хамрагдсан ХШҮ хариуцсан албан хаагчдын тоо, сэтгэл ханамжийн хувь	2024 онд зохион байгуулсан сургалтад хамрагдсан ХШҮ мэргэжилтний тоо -24, Сэтгэл ханамжийн судалгааны хувь-91	Төрийн захиргааны болон төв, орон нутгийн харьяа байгууллагын ХШҮ, дотоод хяналт хариуцсан-50, Сэтгэл ханамжийн судалгааны хувь-91	I улирал	ХШҮДАГ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын төрийн захиргааны болон төв, орон нутгийн харьяа байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Удирдлагын академийн Б байранд зохион байгуулав. Сургалтад 21 аймгийн СУАЖЗГ, БТСГ, нийслэл, 9 дүүргийн БТСХ-ны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, харьяа 25 байгууллагын тайлан, төлөвлөгөө хариуцсан нийт 80 албан хаагч хамрагдсан. Сургалтыг хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх болон салбарын харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, тайлагналд дүн шинжилгээ хийх арга зүй гэсэн 2 модулиар 3 дадлага ажлын хүрээнд зохион байгууллаа.
1.2.	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналт хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулах		Зохион байгуулсан сургалтын тоо	2024 онд зохион байгуулсан сургалт -1, Сэтгэл ханамжийн судалгааны хувь-91	Сургалтын тоо-6	III-IV улирал	ХШҮДАГ	Баян-Өлгий, увс, хэнтий, дорнод, Сэлэнгэ, дархан-уул аймгийн харьяа байгууллагуудын 360 албан хаагчдад хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод хяналт шалгалтын чиглэлээр сургалт зохион байгуулах хөтөлбөр, удирдамжийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/76 дугаар тушаалаар батлуулж, сургалтыг дараах байдлаар зохион байгуулав. Үүнд: 1.Увс аймагт 2025 оны 09 дугаар сарын 12 -ны өдөр 14 байгууллагын 60 албан хаагч, 2.Баян-Өлгийн аймагт 09 дүгээр сарын 18-ны өдөр 17 байгууллагын 60 албан хаагч, 3.Хэнтий аймагт 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр 27 байгууллагын 150 албан хаагч, 4.Дорнод аймагт 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 19 байгууллагын 101 албан хаагч, 5. Дархан-Уул аймагт 2025 оны 08 дугаар сарын 16 -ны өдөр, Сэлэнгэ аймагт 2025 оны 08 дугаар сарын 17-18 ний өдрүүдэд салбарын нийт 47 байгууллагын 136 албан хаагч, нийт 124 байгууллагын 507 албан хаагчдад тус тус сургалтыг зохион байгуулж, гэрчилгээ олгосон байна.

1.3.	Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 конвенцын үндэсний сургагч багш бэлтгэх сургалтын III шатны сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.	Дэмжлэг үзүүлж, зохион байгуулсан сургалтын тоо, сертификатыг олгосон сургагч багшийн тоо	Сургалт – 1 Сертификат олгосон сургагч багш - 40	Сургалт – 1 Сертификат олгосон сургагч багш - 40	III улирал	СӨБХЗГ	2025 оны 09 дүгээр сарын 22-26-ны өдрүүдэд ССАЖЗЯ, ЮНЕСКО-ийн ивээл дор үйл ажиллагаа явуулдаг Ази, Номхон далайн бүс нутгийн биет бус соёлын өвийн олон улсын сургалтын төв (CRINAP)-тэй хамтран соёлын биет бус өвийн боловсролын орчин үеийн арга зүйг эзэмшүүлэх, үндэсний хэмжээнд сургагч багш бэлтгэх, чадавхыг дээшлүүлэх зорилгоор “Соёлын боловсролын үндэсний сургагч багш бэлтгэх сургалт”-ыг зохион байгуулав. Сургалтад 21 музей, номын сан болон судалгааны байгууллага, 21 аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, ЗГХА Соёл, урлагийн газрын соёлын өвийн асуудал хариуцсан 22 мэргэжилтэн, мөн холбогдох бусад байгууллагын 5 төлөөлөл, нийт 48 мэргэжилтэн хамрагдсан. Оролцогчид соёлын биет бус өвийн эрсдэлийн үнэлгээ, уур амьсгалын өөрчлөлт, олон улсын бодлого хэрэгжилттэй холбоотой онол-практикийн мэдлэгийг системтэйгээр эзэмшсэн. Сургалтад оролцогчдод “Сургагч багш”-ийн эрх олгож батламж гарлуулсан.
1.4.	“Төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн хуулийг зөв хэрэглэх нь”	Сургалтын тоо, сургалтад хамрагдсан Хүний нөөц хариуцсан албан хаагчдын тоо	-	Сургалт-1, Харьяа байгууллагын захиргаа, хүний нөөц хариуцсан албан хаагч-50	I улирал	ХНХ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хүний нөөцийн хэлтэс, Удирдлагын академийн Төрийн инновац, хөгжлийн албатай хамтран ЗГХА Соёл, урлагийн газар, ЗГХА Биеийн тамир, спортын улсын хороо, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Нийслэлийн биеийн тамир, спортын газар, Нийслэлийн соёл, урлагийн газар болон харьяа байгууллагуудын хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах богино хугацааны сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, 40 албан хаагчийг хамруулав. Тус сургалтыг “Хүний нөөцийн бодлого, хөгжлийн чиг хандлага”, “Төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуулийг зөв хэрэглэх нь”, “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого”, “Ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байдлаар тохируулах нь” агуулгын хүрээнд зохион байгуулав.
1.5.	“Хүний нөөцийн бодлого, сургалт хөгжүүлэлт” сургалт	Сургалтын тоо, сургалтад хамрагдсан Хүний нөөц хариуцсан албан хаагчдын тоо	-	Сургалт-1, Харьяа байгууллагын захиргаа, хүний нөөц хариуцсан албан хаагч-50	I улирал	ХНХ	

1.6.	“Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал” сургалт	Сургалтын тоо	-	Сургалт-1, Харьяа байгууллагын удирдлага-25	I улирал	ХНХ, ТАЗ-ийн Салбар зөвлөл	Тус яамнаас Удирдлагын академийн Төрийн инновац, хөгжлийн албатай хамтран төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, удирдлагын манлайллыг нэмэгдүүлэх, ёс зүй, сахилга хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор ЗГХА Соёл, урлагийн газар, Биеийн тамир, спортын улсын хороо, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Биеийн тамир, спортын газар, Соёл, урлагийн газар болон харьяа соёлын байгууллагын 45 удирдах албан тушаалтнуудад "Төрийн албаны ёс зүй, манлайлал, байгууллагын соёл" сэдэвт сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулав. Мөн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2025 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Өвөрхангай аймагт, 4 сарын 26-ны өдөр Орхон аймагт, 5 дугаар сарын 10-ны өдөр Дундговь аймагт, 5 дугаар сарын 25-ны өдөр Сэлэнгэ аймагт зохион байгуулсан. Зөвлөгөөний үеэр Ёс зүйн дэд хорооны дарга Б.Даваацэрэн нь Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал сэдвээр сургалт орж нийт 5 удаагийн сургалтаар 500 гаруй албан хаагчид хамрагдав.
1.7.	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025-2028 оны стратеги төлөвлөгөө танилцуулах сургалт	Сургалтын тоо	-	Сургалт-1	I улирал	ТЗУГ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр "Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг танилцуулах сургалт"-ыг зохион байгуулав. Сургалтад тус яамны газар, хэлтсийн дарга нар ЗГХА Соёл, урлагийн газар, ЗГХА Биеийн тамир, спортын улсын хороо, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Соёл, урлагийн газар, Аялал жуулчлалын газар болон яамны харьяа байгууллагуудын удирдлагууд хамрагдав. Сургалтаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг танилцуулж, "Харьяа байгууллагуудын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд анхаарах болон тулгамдсан асуудал", "Харьяа байгууллагуудын 2024 оны үйл ажиллагааны үнэлгээ, анхаарах асуудлууд" сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж, санаа солилцов.

1.8.	“Төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, тайлагналд анхаарах асуудал” сургалт	Сургалтын тоо	-	Сургалт-1, Төрийн захиргааны болон, харьяа байгууллагын санхүү, нягтлан, нярав, өмч хариуцсан албан хаагч -50	II улирал	ХНХ	Байгууллагын дарга, захирал, нягтлан бодогч, өмч хамгаалах зөвлөлийн гишүүдэд төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, тайлагналын талаарх мэдлэг олгох, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, төрийн өмчийн бүртгэл, ашиглалтыг сайжруулах зорилгоор ЗГХА Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр тус сургалтыг Монгол Улсын Үндэсний номын сангийн салбар байранд зохион байгуулав. Сургалтад яам болон харьяа агентлаг, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нийт 71 хүнийг хамруулав.
1.9.	“Байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх аргачлал” сургалт	Сургалтын тоо, сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	Сургалт-1	III улирал	ХНХ	Ажлын байрны чиг үүргийн шинжилгээг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид төрийн байгууллагын чиг үүргийг хэрхэн тогтоосон, түүнд хамаарах эрх, зүйн орчин болон бодлого, стратеги, хөтөлбөр, бүтэц, зохион байгуулалт, төсөв, зардалд зохих арга зүй ашиглан иж бүрэн дүн шинжилгээ хийх зорилгоор ЗГХА Соёл, урлагийн газар, Нийслэлийн Соёл, урлагийн газар, яамны харьяа байгууллагуудын захиргаа, удирдлагын нэгжийн дарга, хүний нөөцийн ажилтнуудад “Байгууллагын болон ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийх аргачлал” сэдэвт сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулав. <u>Сургалтад нийт 27 байгууллагын 50 албан хаагч хамраглав.</u>
1.10.	“Архив, албан хэрэг хөтлөлт”-ийн чадавхжуулах сургалт	Сургалтын тоо, сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	Сургалт-1 харьяа байгууллагын архив, бичиг хэрэг хариуцсан албан хаагч -50	IV улирал	ТЗУГ	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/129 дүгээр тушаал болон Архивын улсын үзлэгт бэлдэх, Ажлын хэсгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд албан хаагчдад Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар сургалтыг Архивын ерөнхий газартай хамтран 2025 оны 09 дүгээр сарын 25-ний өдөр Монгол Улсын Үндэсний номын сангийн салбар номын сангийн байранд зохион байгуулсан Сургалтад ЗГХА Соёл, урлагийн газар, Биеийн тамир, спортын улсын хороо, нийслэлийн Соёл, урлагийн газар, Аялал жуулчлалын газар, Биеийн тамир, спортын газар яамны харьяа байгууллагуудын архив, бичиг хэрэг болон холбогдох бусад чиг үүрэг хариуцсан 164 албан хаагчийг хамруулав.. Сургалтаар Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн стантартыг мөрдөх, цахим архив үүсгэх зэрэг агуулгын хүрээнд мэдээлэл өгөв.

1.11.	“Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн байгууллагын ёс зүйн дэд хорооны ажиллах журам” сургалт	Сургалтын тоо, сургалтад хамрагдсан - албан хаагчдын тоо		Сургалт-1	IV улирал	Ёс зүйн дэд хороо	Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд: Ёс зүйн дэд хорооны гишүүд, яамны болон харьяа агентлаг байгууллагын албан хаагчдад дараах сургалтуудыг зохион байгууллаа. Үүнд 1. Ёс зүйн хорооноос 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр цахимаар зохион байгуулсан “Төрийн байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн дэд хороодыг чадавхжуулах” сэдэвт сургалт, 2.2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Монгол Үндэсний түүхийн музейн 50, Ёс зүйн дэд хорооны 5 албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ", "Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх нь" сэдэвт сургалт, 3.2025 оны 6 дугаар сарын 05-ны өдөр Үндэсний номын сангийн 60 албан хаагч, Ёс зүйн дэд хорооны 5 албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ", "Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх нь" сэдэвт сургалт тус тус зохион байгуулсан.
1.12.	“Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалт	Сургалтын тоо	Сургалт-1	Сургалт-1	IV улирал	ХЭЗХ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн захиргааны удирдлагын газраас Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Улсын хүүхэлдэйн театрт зохион байгуулав. Уг сургалтад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, харьяа байгууллагуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг мэдүүлдэг нийт 100 гаруй албан хаагч хамрагдав. Сургалтаар Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар С.Янжинлхам авлигын эсрэг хууль тогтоомж, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, оролцогчдын асуултад хариулж, соёл, спортын салбарыг шударга байдлын манлайлалтай ажиллахыг уриалав.

1.13.	Хүний эрх, хүүхэд хамгааллын бодлогын сургалт	Сургалтын тоо	Сургалт - 2	Сургалт - 1	IV улирал	ТЗУГ, ХБХЭХДЗ, ЖСЗ, ХЭХДЗ	Жил бүрийн 9 дүгээр сарын 4 дэх долоо хоногт тохиодог Сонсголын бэрхшээлтэй иргэдийн эрхийн долоо хоногийг тохиолдуулан төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд хүргэж буй мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээлэл авах эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг албан хаагчдад хүргэх зорилгоор “Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр И Монгол академи УТҮГ-тай хамтран зохион байгуулав. Сургалтад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болон харьяа агентлаг, байгууллагуудын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах болон хүний нөөцийн асуудал хариуцан ажилладаг 30 албан хаагчийг хамруулав. Хүүхдийг гэмт хэрэг, эрсдлээс урьдчилан сэргийлэх, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуульийн хэрэгжилтийг хангах хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газартай хамтран “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, таних арга, хууль эрх зүйн хариуцлага” сэдэвт 3 удаагийн сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 21-нд Монгол Улсын Үндэсний номын сан, 10 дугаар сарын 30-ны өдөр ЗГХА Биеийн тамир спортын улсын хороонд тус тус зохион байгуулав. Эхний сургалтад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 45, хоёр дахь сургалтад яамны харьяа агентлаг, байгууллагуудын 55, гурав дахь сургалтад Биеийн тамир, спортын улсын хорооны 25, нийт 125 албан хаагчийг хамруулав.
-------	---	------------------	-------------	-------------	--------------	------------------------------------	---

Хоёр. Яамны албан хаагчдыг чадавхжуулах сургалт							
2.1.	Удирдлагын Академийн төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад яамны албан хаагчдыг хамруулах	Сургалтад хамруулсан албан хаагчдын тоо	10	10-с доошгүй албан хаагч	Жилдээ	ХНХ	Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны эхний хагас жилд Удирдлагын академийн эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад-2, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад-2, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад-5, Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад-2, нийт 11 албан хаагчийг хамруулсан. Төсвийн тодотголтой холбоотойгоор Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад албан хаагчдыг улсын зардлаар хамруулах боломжгүй болсон тул 2025 оны сүүлийн хагас жилд тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 1, ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 2, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад 2, төрийн албанд анх томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх богино хугацааны сургалтад 2, нийт 7 албан хаагч өөрийн зардлаар суралцав.
2.2.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сургалт	Сургалтын тоо, сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	Сургалт-1, яамны төрийн захиргааны албан хаагч-60	I улирал	ХНХ	2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Удирдлагын академийн Төрийн инновац, хөгжлийн төвтэй хамтран төрийн захиргааны гүйцэтгэх албан хаагчдын төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах чадварыг сайжруулах богино хугацааны сургалтыг зохион байгуулав. Сургалтад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 47 төрийн захиргааны албан хаагч хамрагдав. Сургалтаар “Байгууллагын нэгж, албан хаагчийн төлөвлөгөөний уялдааг хангах нь”, “Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг төлөвлөх нь”, “Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, суурь болон хүрэх түвшнийг төлөвлөх нь” гэсэн агуулгын хүрээнд албан хаагчдад мэдээлэл өгч, практик дасгал ажиллуулав.

2.3.	“Архив, албан хэрэг хөтлөлт”-ийн чадавхжуулах сургалт	Сургалтын тоо	-	Сургалт-1, яамны төрийн захиргааны албан хаагч-60	III улирал	ТЗУГ	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/129 дүгээр тушаал болон Архивын улсын үзлэгт бэлдэх, Ажлын хэсгийн төлөвлөгөөг үндэслэн албан хаагчдад Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар сургалтыг Архивын ерөнхий газартай хамтран 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсын Үндэсний номын сангийн салбар номын сангийн байранд зохион байгуулсан Сургалтад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 74 албан хаагч хамрагдав. Сургалтаар Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн стантартыг мөрдөх, цахим архив үүсгэх зэрэг агуулгын хүрээнд мэдээлэл өгч, сургалтад хамрагдсан нийт албан хаагчдаас албан хэрэг хөтлөлтийн мэдлэгийн түвшин тогтоох сорил авсан.
2.4.	Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт	Сургалтын тоо	Сургалт - 1	Сургалт-1	Жилдээ	ХЭЗХ, Ёс зүйн дэд зөвлөл	Ёс зүйн хорооноос 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр цахимаар зохион байгуулсан “Төрийн байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн дэд хороодыг чадавхжуулах сургалт”-д ССАЖЗЯ-ны ЁЗДХ-ны бүрэлдэхүүн болон харьяа байгууллагын дэргэдэх ЁЗДХ-ны гишүүдийг хамруулан ажиллав. Мөн тайлант хугацаанд 1 удаагийн сургалт зохион байгуулж, албан хаагчдад зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.
2.5.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг олгох сургалт	Сургалтын тоо	-	Сургалт-1	Жилдээ	ТЗУГ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, албан хаагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, бататгах зорилгоор 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль тогтоомж” сэдэвт сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Улсын хүүхэлдэйн театрт зохион байгуулав. Сургалтад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны албан хаагчид, болон харьяа агентлаг, байгууллагуудын захирал, захиргаа, удирдлагын нэгжийн дарга, хүний нөөцийн асуудал хариуцсан нийт 112 албан хаагч хамрагдав. Сургалтыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Нэгдсэн төлөвлөлтийн хэлтсийн шинжээч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэшсэн ажилтан Х.Батсайхан чиглүүлж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах талаарх мэдээлэл өгсөн..

2.6.	“Авлига болон ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх” сургалт	Сургалтын тоо	Сургалт-1	Сургалт-1	IV улирал	ХЭЗХ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн захиргааны удирдлагын газраас Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Улсын хүүхэлдэйн театрт зохион байгуулав. Уг сургалтад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 50 гаруй албан хаагч хамрагдав. Сургалтаар Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар С.Янжинлхам авлигын эсрэг хууль тогтоомж, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэл өглөө.
2.7.	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, үнэлгээ хийлгэх	Сургалтын тоо, үнэлгээний тайлан	-	Сургалт – 1 Үнэлгээний тайлан – 1	IV улирал	ТЗУГ	Төрийн албаны тухай хууль, ССАЖЗЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 дугаар хавсралтаар батлагдсан Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Төлөвлөгөөнд төсөвтэй тусгагдсан сургалтуудыг зохион байгуулахаар сайдын 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн “Зардал батлах тухай” А/420 дугаар тушаалаар 57 сая төгрөгийн зардал батлуулсан. Тушаалын хэрэгжилтийг хангаж, гамшгийн эрсдэлээс хамгаалах, албан хаагчдыг хөгжүүлэх, эрүүл амьдралын хэв маяг, дадал төлөвшүүлэх, хүний эрх, хүүхэд хамгааллын тухай бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зэрэг агуулгын хүрээнд сургалтуудыг зохион байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байсан боловч Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар гарсантай холбогдуулан сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулж, сургалт зохион байгуулах боломжгүй болсон.
2.8.	Хувь хүний хөгжлийн сургалт	Сургалтын тоо хамрагдсан албан хаагчийн тоо	Сургалт – 1	Сургалт – 2, албан хаагчдын тоо – 80	IY улирал	ТЗУГ	
2.9.	Гадаад хэлний мэдлэг дээшлүүлэх сургалт	Сургалт зохион байгуулсан эсэх	-	Сургалт – 1	IY улирал	ТЗУГ	

2.10.	“Хиймэл ашиглаж гүйцэтгэлээ нэмэгдүүлэх сургалт	оюун нь”	Сургалтын тоо хамрагдсан албан хаагчийн тоо	-	Сургалт – 1, албан хаагчдын тоо – 60	IY улирал	ХНХ	Албан хаагчдын цахим ур чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр "Хиймэл оюун ашиглан ажлын гүйцэтгэл нэмэгдүүлэх нь" сэдэвт сургалт зохион байгуулав. Сургалтыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын орон тооны бус зөвлөх Б.Золбадрал удирдан явуулсан бөгөөд хиймэл оюуныг өдөр тутмын ажил, амьдралдаа ухаалгаар ашиглаж бүтээмжээ нэмэгдүүлэх арга замын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Сургалтаар хиймэл оюуны технологийн хөгжил, хэрэглээний боломж, мэдээлэл боловсруулах аргачлал, ёс зүйн болон аюулгүй байдлын асуудлыг онцлон тайлбарлаж, бодит жишээнд тулгуурласан практик аргачлалуудыг танилцуулсан бөгөөд оролцогчид хиймэл оюуныг ажлын гүйцэтгэл, төлөвлөлт, болон шийдвэр гаргалтад хэрхэн үр дүнтэй ашиглаж болох талаар туршлага солилцлоо. Хиймэл оюуны технологийг зохистой, хариуцлагатайгаар ашиглаж хэвших нь байгууллагын ажлын төлөвлөлтийг оновчтой болгох, бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зэрэг олон талын ач холбогдолтойг сургалтад оролцогчид онцолж байв
2.11.	Эрүүл боловсрол амьдралын дадал төлөвшүүлэх сургалт	мэндийн олгох, зөв хэвшил	Сургалтын тоо хамрагдсан албан хаагчийн тоо	Сургалт – 1	Сургалт – 1, албан хаагчдын тоо – 60	IY улирал	БТСБХЗГ, ТЗУГ	Хамт олны эв нэгдлийг бэхжүүлэх, ажлын болон амралтын зохистой харилцааг хангах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, ажилтан, албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх зорилтын хүрээнд "Эерэг хандлага-идэвхтэй хөдөлгөөн" сэдэвт спортын өдөрлөгийг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Төв аймаг дахь Монголын хөлбөмбөгийн холбооны олон улсын бэлтгэлийн төвд зохион байгуулав. Арга хэмжээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 65 албан хаагч хамрагдсан. Арга хэмжээний үеэр Эрүүл мэндийн боловсрол олгох, амьдралын зөв дадал хэвшил төлөвшүүлэх сургалт, хөгжилтэй хөл бөмбөг, чөлөөт цагийн дасгал, Манзуширын хийд рүү спорт алхалт хийх үйл ажиллагааг зохион байгуулав.